



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/373

Хэрлэн сум

Талбайн нөхөн сэргээлтийн ажлыг
хүлээж авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Газрын хэвлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1 дэх заалтууд болон Засгийн газрын 2014 оны "Журам батлах тухай" 222 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийн 3.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд хийгдэж буй дэд бүтцийн ажлуудын нөлөөгөөр эвдрэлд орсон талбайн нөхөн сэргээлтийн ажлыг хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
дарга

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Нарийн бичгийн
дарга

Газрын харилцаа барилга, хот байгуулалтын
газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд:

Байгаль орчин аялал жуулчлалын газрын Газар,
газрын хэвлий түүний баялгийн ашиглалт, уул
уурхай, БОНБҮнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын
Байгальорчны хяналтын улсын /ахлах/ байцаагч

Тухайн сумын Засаг дарга


Тухайн сумын Татварын байцаагч

Тухайн сумын Газрын даамал

Тухайн сумын Байгаль орчны хяналтын улсын
байцаагч, байгаль хамгаалагч

2. Нөхөн сэргээлтийн ажлыг хууль тогтоомжид заасны дагуу хүлээн авч, акт үйлдэн баталгаажуулан дүн мэдээг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор танилцуулж ажиллахыг Ажлын хэсгийн даргад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ